



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/366

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 17 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.7.1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдаж буй залуучуудын гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, цус ойртолт ба угийн бичиг хөтлөхийн ач холбогдол, үнэт зүйл, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх, нийгэм дэх тэдний оролцоог дэмжих зорилгоор зохион байгуулах гэж буй "Жангар фестиваль" залуучуудын бүсийн нэгдсэн арга хэмжээнд хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах 26,675,000 (хорин зургаан сая зургаан зуун далан таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг ажлын хэсэг (М.Эрдэнэбилэг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР